тасралтгүй харилцан ажиллагаатай байх шаардлагатай бөгөөд өнөөдөрийн байдлаар эдгээр байгууллагуудын үйл ажиллагааг улсын хилийг эдийн засгийн аргаар хамгаалахад нь нэгтгэн чиглүүлсэн зөвлөмж, эрх зүйн акт, хууль тогтоомжууд, заавар, дүрмүүд хараахан гараагүй байгааг гаргах нь зүйтэй юм.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн*
*821 дүгээр дамжааны сонсогч,*
*дэд хурандаа С. Энхзориг*

## МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХИЛИЙН ОТРЯДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр бүлгийн 1.1-д “Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн”, 4.1-д “Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна” гэж заасан.

“Газар бол улсын үндэс” энэ хэдхэн үгнээс бүрдсэн өгүүлбэр юу юунаас чухал содон юм. “Улс буй цагт хил бий” гэсэн үгч бий,дээрхи хоёр тодорхойлолт харилцан бие биедээ татагдсан, хамаарал бүхий “Төрт улс, газар нутаг, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, язгуур ашиг сонирхолыг агуулсан ойлголт юм. Энэ ойлголт ямарч улс гүрэнд хамааралтай буй заа. Газар нутаггүй улс гэж үгүй, улс л юм бол газар нутгаа зааглаж, тодорхойлж, тогтоосон шугам (хил)-тай байх нь зүй. Тэгвэл туурга тусгаар улс бүхэн өөрийн гэсэн ашиг сонирхол, оршин тогтнохын аюулгүй байдлаа хадгалж, дэлхийн улс гүрнүүдтэй мөр зэрэгцэн харилцаж, дуу хоолойгоо хүргэж байдаг билээ.

***Аюулгүй байдал** гэдэг бол аюулгүй, бүрэн бүпгэн байх, найдвартай, итгэлтэй байх; аймаар юмгүй, айх болгоомжлох ишардлагагүй; аюулаас бодитойгоор хамгаалагдсан байдал, түүнийг найдвартай сөрөн зогсох чадвар” гэж томъёологдсон байдаг.*Аюулгүй байдлын тогтолцоо “хэврэг” байх нь улс орон задрах, үндэстэн ястан устах, зэвсэгт мөргөлдөөн үүсэх, материаллаг үнэт зүйлс эвдрэн сүйдэх, бусдын эрхшээлд орох зэрэг гай гамшигт хүргэнэ.

**Аюулгүй байдлыг хангах** гэдэг нь учирч болзошгүй аюулыг баттай мэдээлэл, нарийн судалгаа, тооцооны үндсэн дээр урьдчилан бодитойгоор төсөөлөн харж мэдэх, тухайн аюулаас сэргийлэхийн тулд бүх бэлтгэлээ урьдчилан хангаж шийдвэртэй ажиллаж амжилтад хүрэх чадвар мөн.

*Аливаа байгаль, нийгмийн юмс, үзэгдэл байнгын хөгжил, хөдөлгөөнд байдаг болохоор, өчигдөрхөн л хөдөлбөргүй, маргаангүй мэт санагдаж байсан юмс өнөөдөр ач холбогдлоо алдах юмуу, шинэ хэлбэрт шилжиж байна.*

Хилийн орчинд Монгол Улсынашиг сонирхолд учирч болзошгүй аюул, занал өнөө хэр хадгалагдсаар байгаа төдийгүй хэмжээ далайц, эрчим төрөл нь ихсэх хандлагатай байна. Ялангуяа учирч болзошгүй аюулын тухай бидний төсөөлөлд ихээхэн өөрчлөлт орж, уламжлалт аюулын зэрэгцээ “үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хүний наймаа, мансууруулах бодисын зөөвөр, цөмийн түүхий эд материал дамжуулан худалдаалах, үйлдвэрлэх оролдлого, байгалийн гамшигт үзэгдэл, дэлхийн цаг уурын дулаарал, хүний амьдрах орчны бохирдол, нэн

халдварт өвчний тархалт, олныг хамарсан ядуурал, эмх замбараагүй дүрвэлт зэрэг улс орны хил хязгаараар зааглагддаггүй уламжлалт бус аюулын хүрээ өргөжиж байгаагийн дотор олон улсын терроризм дэлхий нийтийг хамарсан шинэ аюул занал болон хувирч байна".

Эцсийн эцэст хилийн аюулгүй байдал нь төр, нийгэм, иргэдийн язгуур эрх ашгийг хилийн орчинд хангах замаар үндэсний хийгээд, улс хоорондын аюулгүй байдлыг хангах тогтвортой урьдчилсан нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

Тиймээс хилийн аюулгүй байдал гэдэг нь улсын хилийн орон зай(орчин)-д төр, нийгэм, иргэний амьдрах ашиг сонирхол баталгаатай хангагдсан байхыг хэлнэ.

*Өчигдрийн дайснууд наанаа хуурамч, нөхөрсөг дүр эсгэвч цаанаа мэдээлэл, санхүү-эдийн засаг, үзэл суртал, соёлын талаар түрэмгийлэх, түрэмгийллийн шинэ хэлбэрт шилжиж эхэллээ. Энэ бүхэн улс орны хил хязгаарын аюулгүй байдлыг хангах тогтолцоог үүнд зохицуулахыг зүй ёсоор шаардаж байна.*

Улсын хилийн аюулгүй байдлын эрх зүйн хангалт нь хилийн аюулгүй байдлыг эрх зүйн талаар хангах тогтолцооны агуулгыг тусгасан дараахь үндсэн элементүүдээс бүрдэнэ. Үүнд:

1. Олон улсын эрх зүйн хангалт:
2. Хууль эрх зүйн хангалт:
3. Хуульчилсан эрх зүйн актуудын хангалт.

"Улсын хилийн эрх зүйн байдал"-ын тухай ойлголтын агуулгад Монгол улсын хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээгээр улсын хилийн шугамын явалтыг тодорхойлох, тогтоох, тодотгох, хилийн дэглэмийг зохицуулах, тэдгээрт хяналт тавих асуудлууд хөндөгддөг байна.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлогод ''Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг шинжлэх ухаан, техник, технологийн ололт, мэргэшсэн байгууллагын үйл ажиллагаанд тулгуурлан цогц байдлаар зохион байгуулна", мөн энэ хүрээнд *ажлаа явуулдаг тусгай байгууллагыг байгуулна* гэдэг нь төр өөрөө улсын хилийн аюулгүй байдлыг хангах асуудлыг хүлээн зөвшөөрч буйн илрэл мөн. Энэ хилийн отряд нь улсын хилийг дан ганц манаж хамгаалах бус хил орчмын нутагт аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий шинэ чиг хандлага тулгарч байгааг гэрчилж байна.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын 2 дугаар бүлгийн 3.1-д "Хил хамгаалах албыг ямар ч нөхцөлд *улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах чадвар бүхий нэгдмэл бүтэц, зохион байгуулалттай байлгах.*

Хилийн аюулгүй байдлын удирдлага нь тухайн бүс нутгийн хөгжил дэвшил хилээсээ эхлэн хөгжих, хөгжлөөр тэргүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ.Улсын хилийн аюулгүй байдлын удирдлагыг *улс орны хэмжээнд* болон *орон нутгийн төвшинд* хэрэгжүүлнэ. Улс орны хэмжээнд улсын хил дээрүүссэн будлиан, эмх замбараагүй байдал, гамшиг осол, хилийг хамтран шалгах тохиолдолд хил залгаа улсууд хилийн хамтарсан комисс байгуулан асуудлыг нэн даруй зохицуулах замаар хил хязгаарын аюулгүй байдлыг хангана.

Орон нутгийн төвшиндхилийн ус бохирдсон, хүн малын гоц халдварт өвчин гарч байдал хурцадсан зэрэг тохиолдолд хил залгаа улсуудын мэргэжлийн

байгууллагууд хамтран ажиллах, асуудлыг бүс нутаг, хилийн төлөөлөгчийн шугамаар авч хэрэгжүүлэн зохицуулна.

Монгол Улсын хил нь мөн адил хөрш улсын хилийн шинжийг агуулдаг бөгөөд айл зэргэлдээ улстай хамтран зөвшилцөж, олон улсын эрх бүхий байгууллагаар баталгаажсан учраас Монгол улс хилийнхээ шугам, багана, тэмдэг, холбоосыг найдвартай хамгаалах арга хэмжээ авснаар олон улсын зарчмаас гажих, хөршийнхөө итгэлийг эвдэх бус харин хоёр улсын найрамдал, ард түмний нөхөрлөл, хамтын ажиллагааг улам бэхжүүлэх, “хоёр улс, нэг хил” гэсэн зарчмыг баримтлан Монгол улсын нэр хүндийг дэлхий дахинд өргөж, олон улсын талархал хүлээж, монголын ард түмэн олон зуун жил амар төвшин аж төрөх нөхцлөөр хангагдана.

Өнөөгийн Засгийн газар шинэчлэлийн бодлого баримталж, түүнийгээ хэрэгжүүлэхэд чиглэн ажиллаж байна. Үүнтэй уялдуулан Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр (шинэчлэлийн мөрийн хөтөлбөр ч гэж нэрлэх болсон)-т “Дотоод хэргийн чиг үүрэг давамгайлсан байдлыг халах замаар "хууль зүйн яамны чиг үүрэг, зохион байгуулалтыг өөрчлөн боловсронгуй болгож, хууль зүйн бодлогыг шинжлэх ухааны үндэстэй, хүний эрх, эрх зүйт ёсны зарчимд нийцүүлэх механизмыг бий болгох”гэж зааснаар хууль зүйн яамны харъяа агентлагуудад шинэчлэлийн бодлого эрчимтэй үргэлжилж байна. Ингэснээр “Хууль сахиулах” гэсэн нэр томъёог хэрэглэх болж, хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын бүтцийн болон эрхзүйн шинэтгэл эрчимтэй үргэлжилж байна.

Монгол Улсын хил хамгаалах байгууллага нь Хууль зүйн яамны харъяа бөгөөд Засгийн газрын тохируулагч агентлагийн хувьд хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллага юм. Мөн Монгол Улсын Батлан хамгаалахын тухай хуульд заасны дагуу бусад цэргийн бүрэлдэхүүнд орж, улс орныг батлан хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Шинэчлэлийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн 4 дүгээр бүлгийн Батлан хамгаалах бодлогын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний 4 дэх хэсэгт “хил хамгаалах бодлогыг *шинээр пюдорхойлж,* улсын хилийн хамгаалалтад орчин үеийн зэвсэглэл, техникийг нэвтрүүлэх” (Байгууллагын техник, технологийн шинэтгэл), мөн 5 дугаар бүлэгт “захиргааны болон эрүүгийн зөрчлийг бүртгэх нэгдсэн сан бий болгож, эргүүлийн цагдаа, *хилийн алба,* татвар, бусад мэргэжлийн хяналтын үйл ажиллагаанд *эрсдэлийн удирдлагын менежментийг нэвтрүүлэх* (Байгууллагын үйл ажиллагааны шинэтгэл) гэсэн асуудлыг тусгасан. Тэгвэл шинэчлэлийг хэрэгжүүлж буй Засгийн газар, түүний үр нөлөөг идэвхитэй явуулж буй хууль сахиулах байгууллагын шинэтгэлийн үйл явц нь өнөөгийн албан хаагчдад сэтгэлгээгээ өөрчилж, зөв хандлагад төлөвшиж ажиллахыг шаардаж байна.

Монгол Улсын Хил хамгаалах байгууллагаас 2014 онд дэвшүүлсэн зорилтоо“Хил хамгаалах байгууллагын офицеруудын манлайллыг дээшлүүлж, сургалт бэлтгэлийг сайжруулна” гэж тодорхойлсон. Үүнээс харахад хил хамгаалах байгууллагын дээд удирдлагаас нь өөрчлөлт, шинэчлэлийн үйл хэргийг байгууллагадаа нэвтрүүлж хэрэгжүүлэх нь тодорхой байна.

Шинэчлэл хийхэд бүх зүйлийг урьдаар төлөвлөж, оношилж түүнд бэлтгэдэг нь онол, практикаар батлагдсан.Иймд өнөөдөр Хил хамгаалах байгууллагын үндсэн нэгж болох хилийн отрядод алба хааж байгаа бүрэлдэхүүн нь өөрчлөлт,

шинэтгэлийн талаар тодорхой онолын ойлголттой байх, мөн түүнчлэн ангийн удирдлагын зүгээс өөрийн байгууллагын оношлогоог үнэн зөв хийж, өөрчлөлт шинэтгэл хийхэд хүмүүсээ бэлтгэх нь чухал юм. Ялангуяа хууль сахиулагчын төвшинд... Тиймээ анги, отрядын албан хаагчид өөрчлөлт, шинэчлэлтэнд хэрхэн бэлэн байх, түүнийг хэрэгжүүлэх ажлын 70 хувь нь хилийн отрядын дарга (байгууллагын удирдлага)-аас хамаардаг.

Иймд хилийн отрядын дарга нь хууль сахиулах удирдлагын нэг субъект төдийгүй хил орчмын нутагт өөрчлөлт, шинэчлэлийг хэрэгжүүлэгч юм.

Хилийн отрядын офицерын бүрэлдэхүүн өөрчлөлт шинэчлэл, манлайллын талаар мэдээлэл хийж, харилцан ярилцах хэлбэрээр явуулсан судалгаагаар Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн гол үзэл санаа нь “шинэлэлийн бодлого явуулж байгаа" гэсэн хэдий боловч, өөрийн байгууллагын хөрсөн дээр хэрхэн ямар байдлаар хэрэгжүүлэх нь тулгамдсан асуудлуудын нэг болж байна.

**Дүгнэлт**

Хилийн орчинд Монгол Улсынязгуурашиг сонирхолд учирч болзошгүй аюул, занал өнөө хэр хадгалагдсаар байгаа төдийгүй хэмжээ далайц, эрчим төрөл нь ихсэх хандлагатай байна. Энэ нөхцөл байдалд ХХБ-ын удирдлагаас өөрийн байгууллагын өөрчлөлт, шинэчлэлийг байгууллагын соёл, үнэт зүйлд тулгуурлан эрх зүйн болон техник технологийн төвшинд тодорхой үе шаттайгаар авч хэрэгжүүлж байна. Энэ үйл хэргийг улсын хилийн районд буюу улсын хил дээр яаж хэрэгжүүлэх нь хилийн отрядын дарга (удирдлага)-аас шууд хамааралтай юм.

1. Иймд улсын хилийн гадаад, дотоод нөхцөл байдал, цаашдын нөхцөл байдал нь хилийн отрядын өмнө улсын хилийг манаж хамгаалахаас гадна хил орчмын нутагт аюулгүй байдлыг хангах үүрэг тулгарч байгааг гэрчилж байна. Хилийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэгч хилийн отрядын ажиллагааг шинэ нөхцөл байдалд шинэлэг арга хэлбэрээр өөрчлөн сайжруулахыг шаардаж байна.
2. Монгол Улсын төр, засгаас хэрэгжүүлж буй бодлого, Хууль сахиулах байгууллагуудын хүрээнд хэрэгжүүлж буй шинэчлэл, өөрчлөлтийн үйл явц, цаашдын хандлагыг хилийн анги, отрядод хэрхэн буулгаж хэрэгжүүлэх асуудал бүрхэг байна. Өөрийн байгууллагын оношлогоог үнэн зөв хийж, өөрчлөлт шинэтгэл хийх бэлтгэл хангагдаагүй байна.
3. Хилийн отрядын удирдлагыг өөрчлөлт, шинэчлэлийн үйл хэрэгт бэлтгэх, менежментийн шинжлэх ухааны онолын мэдлэг олгох ажил төдийлэн хийгдээгүй.
4. Хилийн анги, отрядын бүрэлдэхүүн болон тодорхой албан тушаал эрхлэж буй хилчдэд эрх зүйн шинэтгэл, өөрчлөлтийн өнөөгийн ’ нөхцөлд хууль сахиулах мэдлэг, чадвартай болох асуудал тулгарч байна.

**Дэвшүүлж буй санал**

1. Хилийн анги, отрядын үйл ажиллагаа, хэтийн төлөвийг цэргийн болон менежментийн шинжлэх ухааны үүднээс оношилж, тэдний үүрэг, зорилгыг тодорхой болгох, хил хязгаар бүс нутагт аюулгүй байдлын тогтолцоог хангах чадвар бүхий нэгдмэл бүтэц, зохион байгуулалтын менежментийг нэвтрүүлэх хэтийн болон дунд шатны төлөвлөгөөг боловсруулж мөрдөх.